



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 163

Мандалговь

Хурдан морины уралдаан зохион
байгуулахыг хориглох тухай

"Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5, Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 6 дугаар зүйлийн 6.2, 24 дүгээр зүйлийн 24.3, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, Хөдөлмөрийн сайдын 2016 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/36 дугаар тушаалаар баталсан "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ын 3.10.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн нутаг дэвсгэрт жил бүрийн 11 дүгээр сарын 1-нээс 5 дугаар сарын 1-нийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, бооцоот уралдаан, мялаалганы найрны уралдаан, уралдааны өмнөх үсэргээ, сунгаа зохион байгуулах, оролцохыг хориглосугай.

Хоёр. Өвөл хаврын байгаль цаг агаарын таагүй нөхцөлд морины уралдааны үед үүсч болзошгүй сөрөг нөлөө, үр дагаврыг олон нийт, ялангуяа уяачид, эцэг эхчүүдэд цаг алдалгүй сурталчилж, сумын хэмжээнд 11 дүгээр сарын 1-нээс 5 дугаар сарын 1-нийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, бооцоот уралдаан, мялаалганы найрны уралдаан, уралдааны өмнөх үсэргээ, сунгаа зохион байгуулах, оролцохыг хориглосон захирамж гарган ажиллахыг сумдын Засаг дарга, "Нарны хүлэг" Морин спорт уяачдын холбоо /Ц.Ганхүү/, сумдын Морин спорт уяачдын холбооны тэргүүн нарт тус тус даалгасугай.

Гурав. Захирамжийн хэрэгжилтэд онцгой хяналт тавьж ажиллахыг мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/, Цагдаагийн газар /М.Ганбаатар/, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Ц.Ганзориг/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200206